



БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ТӨСВИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу.**

Үндэсний аудитын газрын
Санхүүгийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Энхзаяа
Утас:261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Болд
Утас:261885
Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Аудитор: Г.Жавхлан
Утас:261628
Цахим хаяг: javkhlant@audit.gov.mn

Үндэсний аудитын газрын хаяг:
Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-15160,
Монгол Улс

Цахим хуудас: audit.mn

2015 оны 2 дугаар сар

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дах заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын хүрээлэнгийн төсвийн захирагчийн төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2016/42/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Боловсролын хүрээлэнгийн төсвийн 2015 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Боловсролын хүрээлэнгийн төсвийн захирагчийн 2015 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 01 дүгээр сарын 25-наас 2016 оны 02 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Жавхлан хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Боловсролын хүрээлэнгийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланг 2016 оны 01 дүгээр сарын 22-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 01 дүгээр сарын 25-наас 2016 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд Боловсролын хүрээлэнгийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Боловсролын хүрээлэнгийн төсвийн захирагч нь Монгол улсын Боловсролын тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Төсвийн тухай хуульд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол улсын Боловсролын тухай хуулийн 16-р зүйлийн 16.1-д “Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бодлого, шийдвэр боловсруулахад судалгааны мэдээллээр хангах, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын асуудлаар байнгын судалгаа, шинжилгээ, арга зүй, сургалтын ажлыг эрхлэх, орон нутгийн боловсролын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, бүх шатны боловсролын байгууллагад сургалт, судалгаа, арга зүйн мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, боловсролын хөгжлийн асуудлаар шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа явуулах, иргэд, олон нийтэд судалгаа, шинжилгээний мэдээллээр үйлчлэх үйл ажиллагааг эрхэлнэ” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Боловсролын хүрээлэнгийн дарга төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Боловсролын хүрээлэнгийн төсвийн 2015 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Боловсролын хүрээлэнгийн үйл ажиллагааны талаар /ТАБ-СТА-А-1/ маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Боловсролын хүрээлэнгийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Боловсролын хүрээлэнгийн төсвийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн материаллаг байдлын үнэлгээг нийт зардлын 2% буюу 32,390.0 мянган төгрөгөөр тогтоов.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын 3 горим, 6 нарийвчилсан сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад төсвийн шууд захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. Олон улсын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн програм уялдсан байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Боловсролын хүрээлэн нь нягтлан бодох бүртгэлийн Acolous програм ашиглан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Боловсролын хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2015 онд улсын төсвөөс урсгал зардалд 1,612,100.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаанаас 7,400.0 мянган төгрөгийн орлого олсон байна. Үүнээс урсгал зардалд 1,548,738.9 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 62,361.2 мянган төгрөгийг төвлөрүүлж батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 3, нарийвчилсан 6, нийт 9 горим, сорил гүйцэтгэв. Аудитын явцад дараах гол эрсдэлүүдийг олж тогтоов.

- Стандарттай нийцсэн НББ-ийн бодлогын баримт бичигтэй санхүүгийн програм нь нийцээгүй байх
- Хэрэгцээ шаардлага хангахгүй бараа материал байх /эвдэрсэн, хугацаа дууссан, чанаргүй, хоцрогдсон, хугацаа хэтэрсэн гэх мэт/
- Боловсролын хүрээлэнгийн захирлын тушаал буруу гарсан байх
- Хийсэн ажлын хэмжээ, цаг, өдрийг буруу бүртгэсэнээс цалин буруу бүртгэгдэж олгогдсон байх

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Төсвийн захирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 100.0 мянган төгрөгөөс дээш дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/. Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт зардлын 57 хувийг эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Худалдан авсан 3,865.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг бараа материалын орлогод авахгүйгээр шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчил нь санхүүгийн тайлангийн Үнэн зөв батламж мэдэгдлийг зөрчсөн учраас санхүүгийн тайлангийн тодруулгад залруулга хийлгэж, дээрх алдааг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгөв.

2. Боловсролын хүрээлэнгийн захирлын 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 30 дугаар тушаалаар тус байгууллагын 43 ажилтнуудад цалингийн сангаас 90.0 мянга хүртэлх төгрөгийн нийт 3,220.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна. Мөн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал батлагдсан төсвөөс 4,182.7 мянган төгрөгөөр хэтэрсэн нь хэрэгжилтийн багийн цалингийн сан бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ данснаас Боловсролын хүрээлэнгийн цалингийн данс руу 2015 оны 10 сараас эхлэн шилжсэнээс шалтгаалсан байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчил нь Сангийн сайдын баталсан 2014 оны 06 сарын 03-ны өдрийн 122 дугаар “Төсвийн хэмнэлтийн горимд шилжих тухай” тушаалтай нийцэхгүй байгаа тул дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3. Боловсролын хүрээлэнгийн веб сайтын шилэн данс гэсэн цэсийг шалгаж үзэхэд төсвийн гүйцэтгэлийн мэдээнээс өөр мэдээлэл оруулаагүй, веб хуудаст нь шилэн дансны мэдээллийг оруулах цэс суугаагүй байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийг зөрчсөн учраас байгууллагын веб хуудас дах шилэн дансны цэсийг өргөжүүлэх, холбогдох мэдээллүүдийг тухай бүр оруулж хэвших талаар зөвлөмж өгөв.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хүчингүй болсон эрх зүйн акт, журмуудыг мөрдөж байна

Шийдвэрлэсэн: Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоол хүчингүй болсон учраас үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох аргачлалыг өөрийг байгууллагын онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж НББ-ын бодлогын баримт бичигт тусгах

**Материаллаг бүс залруулагдаагүй алдаануудын
талаарх тайлбар:**

Аудитын явцад залруулах материаллаг алдаа тогтоогдоогүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

БСШУЯ-ны хэрэгжилтийн багийн цалин хөлс ба бусад зардал болох 629,663.5 мянган төгрөгийг БСШУЯ-ны ТНБД-ын 2015 оны А/23 тушаалаар Боловсролын хүрээлэнгийн захиралд эрхийг нь шилжүүлж, Боловсролын хүрээлэнгийн дансаар дээрх санхүүжилтийг гарган зарцуулсан байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй байна.

**Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн
зөрчлийн нэгтгэл:**

Төсвийн захирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 7,085.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн холбогдох зөвлөмжийг өгсөн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Боловсролын хүрээлэнгийн 2014 оны санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргаагүй бөгөөд БСШУС-ын ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байна.

Зөвлөмж:

Боловсролын хүрээлэнгийн удирдлагад өгөх 4 зөвлөмжийг менежментийн захидалд дэлгэрэнгүй харуулсан.

Зөрчилгүй санал дүгнэлт

Боловсролын хүрээлэнгийн төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайланг хавсаргав.



БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ТӨСВИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Шилэн дансны тухай2

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2

НББ-ийн бодлогын бичиг баримт.....3

Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:

Асуудал 3

Бараа материалын бүртгэл.....3

Тэргүүлэх ач холбогдол №4 зүйлс:

Асуудал 4

Цалин хөлсний бүртгэл.....3

2010 оны 3 дугаар сарын
01

2015 оны 02 дугаар сар

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараахь хаягаар
харилцана уу:
Газрын захирал:

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Боловсролын хүрээлэнгийн төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Боловсролын хүрээлэнгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

Төсвийн гүйцэтгэлийн мэдээнээс өөр мэдээлэл оруулаагүй, веб хуудаст нь Шилэн дансны мэдээллүүдийг оруулах цэс суугаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Байгууллагын веб хуудсан дах шилэн дансны цэсийг өргөжүүлэх, Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох мэдээллүүдийг цаг тухай бүрд нь бүрэн оруулж хэвших

Эрсдэлүүд

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байх

ҮАГ-ын зөвлөмж

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоол хүчингүй болсон учраас үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох аргачлалыг өөрийг байгууллагын онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж НББ-ын бодлогын баримт бичигтээ тусгах

Эрсдэлүүд

Холбогдох хууль эрх зүйн актыг цаг тухай бүрд нь хэрэгжүүлж ажиллахгүй байх, бүртгэл тайлагнал буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт

Худалдан авсан 3,865.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг бараа материалын орлого авалгүйгээр шууд зардалд хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан тодруулгатай уялдахгүй байх, бүртгэл тайлан буруу илэрхийлэгдэх

ҮАГ-ын зөвлөмж

Дээрх зөрчил нь санхүүгийн тайлангийн Үнэн зөв батламж мэдэгдлийг зөрчсөн учраас санхүүгийн тайлангийн тодруулгад залруулга хийлгэж, дээрх алдааг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгөв.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт

Тайлант оны эцэст Боловсролын хүрээлэнгийн захирлын 30 тоот тушаалаар нийт ажилтнуудыг шагнаж урамшуулсан байна.

Мөн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал батлагдсан төсвөөс 4,182.7 мянган төгрөгөөр хэтэрсэн нь хэрэгжилтийн багийн цалингийн сан бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ данснаас Боловсролын хүрээлэнгийн цалингийн данс руу 2015 оны 10 сараас эхлэн шилжсэнээс шалтгаалсан байна.

Эрсдэлүүд

Засгийн газрын 2014 оны 06 сарын 03-ны өдрийн 122 дугаар “Төсвийн хэмнэлтийн горимд шилжих” тухай тогтоолыг хэрэгжихгүй байх

ҮАГ-ын зөвлөмж

Засгийн газрын 2014 оны 06 сарын 03-ны өдрийн 122 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах, урамшууллыг нийтээр нь хавтгайруулж бус, ажлын өндөр амжилт гаргасан цөөн тооны ажилтныг шалгаруулж шагнаж урамшуулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ Э.ЭНХПҮРЭВ ТАНАА

2016.02.15 № 3/152
танай -ны № -т
Аудитын гэрчилгээ

Боловсролын хүрээлэнгийн төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-т заасан бүрэн эрхийн дагуу Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газраас аудит хийв.

Боловсролын хүрээлэн нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Боловсролын хүрээлэнгийн төсвийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсролын хүрээлэнгийн төсвийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Боловсролын хүрээлэнгийн төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Э.ЭНХЗАЯА

\\10.10.10.20\Bichig_Khered\Yawsan_Bichig\2016\0205SAG6.Docx

УХА0122

070893